

**Рио Тинто компанийн Зэс, нүүрсний группийн Ерөнхий захирал  
Жан Себастьян Жакийн хэлсэн үг  
Монгол Улс, Улаанбаатар хот - 12 дугаар сарын 16, 2015**

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг,

Засгийн газрын гишүүд,

Эрхэмсэг зочид, төлөөлөгчид,

Хатагтай, ноёд оо!

Та бүхэнд өглөөний мэнд хүргэе! Үйл ажиллагаа нь дэлхийн түвшинд хүрсэн “Оюу толгой”-н уурхайн дараагийн шатны бүтээн байгуулалтын нэгэн чухал алхмыг бидэнтэй хамт тэмдэглэхээр Монгол Улсад хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Өмнөговь аймагт урьд нь аливаа барилга байгууламж байгаагүй хоосон газарт ер бусын зүйлийг хамтдаа бүтээн босголцсон “Оюу толгой”-н уурхайгаар мөн Монгол Улсын Засгийн газартай тогтоосон түншлэлээрээ бид маш их бахархаж байна.

Түүнчлэн, олон улсад нэр хүндтэй олон улсын банк санхүүгийн байгууллагууд, АНУ, Канад, Австралийн Засгийн газрыг төлөөлж буй экспортын зээлийн агентлагууд зэрэг хорин байгууллагаар өнөөдөр энэхүү түншлэлийнхээ хүрээг тэлж буйдаа бид баяртай байна.

Бид бүгд “Оюу толгой”-н уурхайг бүрэн хүчин чадалд нь хүргэх эрмэлзлэлтэй бөгөөд уурхайг барьж, бүрэн хүчин чадлаар нь ажиллуулснаар бүх оролцогч талуудад, тэр дундаа Монголын ард түмэнд үр өгөөжөө өгөх юм.

“Оюу толгой” бол дэлхийн хамгийн их нөөцтэй, зэсийн агуулга өндөртэй ордуудын нэг.

Нийт бүлэг орд нь говийн хөрсөн дор бүхэл бүтэн 32 километр буюу 20 миль, барагцаалбал Нью Йоркийн Манхэттен арлын хэмжээтэй дүйцэхүйц уртаар сунан тогтсон.

Шилдэгт тооцогдох энэхүү хүдрийн биетийг бүрэн ашиглах бүтээн байгуулалтын ажил нэлээд урагшилсан байгаа билээ.

Одоо үйл ажиллагаа нь жигдрээд буй ил уурхайг товлосон хугацаанаасаа өмнө буюу хоёр жил хүрэхгүй хугацаанд барьж, ашиглалтад оруулж, 2013 онд анхны бүтээгдэхүүнээ үйлдвэрлэсэн.

Улмаар “Оюу толгой” одоогоор 1.5 сая гаруй тонн зэсийн баяжмал үйлдвэрлээд байна.

“Оюу толгой” компанийн бэлэн мөнгөний чөлөөт урсгал эерэг байгаа бөгөөд зэх зээлийн хүнд хэцүү нөхцөл байдалд зардлаа багасгахын тулд бүтээмжийг өсгөж, зардлын хяналтыг сайжруулахаар шаргуу ажиллаж байна.

Миний бие “Оюу толгой”-н уурхайд зочлон ирэх бүртээ монгол ажилтнууд, олон улсын төлөөллөөс бүрдсэн багийнхаа зүтгэл чармайлтыг олж хардаг.

Мөн “Оюу толгой”-н нийт ажиллах хүчний 95 хувь нь Монгол ажилтнууд байгаагаар бид бахархдаг.

Түүнчлэн, “Оюу толгой” үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй атлаа хэдийнэ ихээхэн ололт амжилт гаргаад буй нь гайхалтай.

Энэ уурхай бол аюулгүй ажиллагааны гүйцэтгэлээр шилдэгт тооцогддог, чадварлаг, эрч хүчтэй ажилтнуудтай, шинийг санаачлахдаа сайн, олон улс даяарх Рио Тинтогийн уурхайнууд дундаас илт ялгардаг бизнесүүдийн нэг юм.

Энэ бол “Оюу толгой”-н уурхайн удирдах ажилтнууд, нийт баг хамт олны гавьяа билээ.

Мөн “Оюу толгой” өнөөг хүртэл татвар болон бусад төлбөр хураамжид 1.3 тэрбум ам.доллар төлж, Монгол Улсад тодорхой хувь нэмэр оруулж ирлээ.

“Оюу толгой” бол Монгол Улсын хувьд олон талаараа, Рио Тинтогийн хувьд зарим талаараа анхдагч төсөл бөгөөд зах зээлийн өнөөгийн тогтворгүй үед энэхүү төсөлд илүү хөрөнгө оруулахын тулд бүх нөхцөл зөв байх шаардлагатай байлаа.

Хэдэн жилийн дараа зэсийн зах зээл нийлүүлэлтийн хомсдолд дахин орж, “Оюу толгой” компанийн хувьд зах зээл илүү тогтвортой болж, үйлдвэрлэдэг металлынх нь үнэ нэмэгдэх нөхцөл бүрдэнэ гэж бид үзэж байгаа.

Бид тавдугаар сард чухал ахиц дэвшил гаргаж, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан билээ. Тус төлөвлөгөөгөөр хувь нийлүүлэгчдийн шийдвэрлэгдээгүй байсан бүх гол асуудлыг шийдвэрлэн, далд уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх үндэс суурийг харилцан тохиролцсон.

“Оюу толгой”-н үйл ажиллагааг ахицтай явуулахад манлайлж, хичээл зүтгэл гарган ажилласан Монгол Улсын Засгийн газарт талархлаа илэрхийлье.

Рио Тинто компани ч мөн адил Монгол Улсын өмнө үүрэг амлалт авсан билээ. Бид өнөөг хүртэл “Оюу толгой” болон Монгол Улсад 6.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд энэ танхимд цугларсан та бүхний олонхтой нь цаашид түншлэн ажиллах болно.

Бидэнд далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд ашиглах 4.4 тэрбум ам.долларын санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн олон улсын санхүүгийн байгууллагуудад талархлаа илэрхийлье.

Би хувиасаа:

Европын сэргээн босголт, хөгжлийн банк

Олон улсын санхүүгийн корпораци

Канадын экспортын хөгжлийн агентлаг

Экспортын санхүүжилт, даатгалын корпораци

АНУ-ын Экспорт, импортын банкинд,

мөн манай зээлдүүлэгч арилжааны байгууллагууд болох:

Австрали, Шинэ-Зеландын банкны групп лимитэд

Би-Эн-Пи Парибас

Канадын Арилжааны империал банк

Кредит Агрикөүл банк

“Эйч-Эс-Би-Ст банк” нээлттэй хувьцаат компани (НХК)

Нидерландын “Ай-Эн-Жи банк” ХК

Интеса Санпаола банкны групп

“Австралийн үндэсний банк лимитэд”

Натиксис

“Сасаете Женерале”

Стандарт Чартеред банк

Сумитомо Мицуй банкны корпораци

Токио-Мицубиши Ю-Эф-Жэй банк лимитэд

“Германы Кэй-Эф-Даблю Айпэкс банк” ХХК

Нидерландын хөгжлийн санхүүжилтийн компани (Недерландсе Финасиерингс-Маачаппиж воор Онтвиккелингсланден ХК)-д тус тус талархлаа илэрхийлж байна.

“Оюу толгой”-г санхүүжүүлэхээр үүрэг амлалт хүлээсэнд, манай төсөлд итгэл хүлээлгэсэнд, мөн Монгол Улсад хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн та бүхэнд баярлалаа.

Төслийн санхүүжилтийн энэхүү гэрээ дэлхийн хэмжээнд нэлээд томд тооцогдох бөгөөд дэлхийд тэргүүлэх энэхүү нөөц баялгийн чанар, ирээдүйн боломж бололцоог илтгэн харуулж байгаа юм.

Түүнчлэн, миний бие үүнийг ирээдүйд уул уурхайн төслүүдийг хэрхэн хөгжүүлдэг болохын, өөрөөр хэлбэл олон түнш хамтдаа эрсдэлээ үүрч, үр өгөөжөө хуваалцдаг болохыг харуулсан томоохон жишээ боллоо гэж үзэж байна.

Бүх хувь нийлүүлэгчдийнхээ нэрийн өмнөөс энд хүрэлцэн ирсэн та бүхэнд төслийн дараагийн энэ чухал үе шатыг хамтран тэмдэглэж байгаад тань талархаж буйгаа илэрхийлье.

Түүнчлэн энэ жил “Оюу толгой”-г идэвхийлэн дэмжсэн, энд байгаа бусад бүх анд нөхөр, түнш, хамт олондоо баярлалаа гэж хэлээд энэ үгээ өндөрлөө.

Бидний ирээдүй илүү гэгээлэг байгаа гэдэгт би итгэлтэй байна.

Бидний өмнө илүү олон сорилт бэрхшээл тулгарах нь гарцаагүй ч бид бүхэнд Оюу толгойг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах нэгдмэл ашиг сонирхол, хүсэл эрмэлзлэл байгаа билээ.

Бидний хамтдаа бүтээн байгуулж байгаа зүйл урт хугацааны, тогтвортой бизнес гэдгийг бид санах хэрэгтэй. Бид Монгол Улс, монголчуудад дараа дараагийн олон үед нь хувь нэмэр оруулах бүтээн байгуулалт хийхийг хүсч байна.

Баярлалаа.